| 310003 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 2,855,683.00 | 2,855,683.00 | - |
| **32** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,408,819.90** | **1,543,769.93** | **(134,950.03)** |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 1,309,213.20 | 1,444,163.23 | (134,950.03) |
| 320002 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 99,606.70 | 99,606.70 | - |
| **33** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **66,374.00** | **28,432.44** | **37,941.56** |
| 330002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 66,374.00 | 28,432.44 | 37,941.56 |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **414,244.80** | **226,635.05** | **187,609.75** |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 190,881.20 | 221,135.05 | (30,253.85) |
| 350003 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 223,363.60 | 5,500.00 | 217,863.60 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **1,738** | **1,728** | **10** |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **9** | **9** | **-** |
| 610001 | Төсвийн байгууллага | 9 | 9 | - |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **212** | **207** | **5.00** |
| 620001 | Удирдах ажилтан | 24 | 19 | 5 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 137 | 137 | - |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 45 | 45 | - |
| 620004 | Гэрээт ажилтан | 6 | 6 | - |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | **1,305** | **1,305** | **-** |
| **630** | **ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД** | **1,015** | **1,015** | **-** |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | 1,015 | 1,015 | - |
| **631** | **СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА** | **290** | **290** | **-** |
| 631001 | Төрийн өмчит СӨБ байгууллага | 290 | 290 | - |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **212** | **207** | **5** |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 10 | 10 | - |
| 650004 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 93 | 93 | - |
| 650006 | Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ) | 4 | 4 | - |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 29 | 29 | - |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 68 | 63 | 5 |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 8 | 8 | - |

### 4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(мянган төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Тайлант он |
|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **681,529.86** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **681,529.86** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **581,036.10** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **104,638.78** |
| 210102 | Нэмэгдэл | 98,050.29 |
| 210104 | Урамшуулал | 6,588.49 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **20,322.43** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 14,659.82 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,988.85 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 713.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 178.25 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,782.50 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **8,815.40** |
| 210401 | Бичиг хэрэг | 568.98 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,430.43 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,816.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **189,696.55** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 165,967.05 |
| 210502 | Хоол, хүнс | 23,729.50 |

| | | |
|---|---|---|
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **66,274.10** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 55,423.00 |
| 210604 | Урсгал засвар | 10,851.10 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **960.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 960.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **12,409.03** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 12,300.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 109.03 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **177,919.82** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 177,919.82 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **100,493.76** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **100,450.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох  бусад тэтгэмж, урамшуулал | 52,200.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 48,250.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **43.76** |
| 213403 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг | 6.00 |
| 213405 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 37.76 |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **686,096.53** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **686,096.53** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 3,449.20 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 39,691.20 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 574,945.33 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 68,010.80 |
| **III** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | **4,566.66** |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 4,566.66 |

## 3. Аудитын тайлан

### 3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хутаг-Өндөр сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төрийн аудитын газрын аудитор Г.Цэрэнлхам гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Хутаг-Өндөр сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 01/97 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

**3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Нутаг дэвсгэрийн нийгэм эдийн засгийн хэтийн хөгжлийн бодлогыг орон нутгийн нөөц боломж, онцлог, улс, аймгийн бодлого чиглэлтэй уялдуулан боловсруулж, сумын нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, ИТХ-ийн Тэргүүлэгчид төрийн гүйцэтгэх захиргааны байгууллага болох сумын Засаг даргыг бүрэн боловсрогдсон бодлогын зөвлөгөө дэмжлэгээр хангаж, тэдний үйл ажиллагааг явуулахад шуурхай үйлчилгээ үзүүлэхэд оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

МУЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам” гэж заасны дагуу тайлант онд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам боловсруулж ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

**3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хутаг-Өндөр сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

**3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 5,147,063.8 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 102,941.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 72,058.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

**3.5 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЙЛБАР, ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

**3.5.1 Мөнгөн хөрөнгө**

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 106.3 хувиар өссөн байна.

*Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл* *(мянган төгрөг)*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Касст байгаа бэлэн мөнгө | 1,831.9 | - | (1,831.9) | (0.6) |
| Банканд байгаа бэлэн мөнгө | 274,894.3 | 570,889.2 | 295,994.9 | 100.6 |
| Дүн | 276,726.2 | 570,889.2 | 294,163.0 | 100.0 |

*Эх сурвалж: Хутаг-Өндөр сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 542,027.4 мянган төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд, 24,295.0 мянган төгрөг арилжааны банкны дансанд, 4,566.6 мянган төгрөг нэмэлт санхүүжилтийн дансанд байршиж байна.

### 3.5.2 Авлага

Авлага дансны үлдэгдэл өмнөх оноос 34.6 хувиар өссөн байна.

*Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл* *(мянган төгрөг)*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Ажиллагчидтай холбогдсон авлага | 628.00 | 15,786.00 | 15,158.00 | 13.78 |
| Төлбөртэй үйлчилгээний авлага | | 237,630.80 | 237,630.80 | 215.99 |
| Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/ | | 183.47 | 183.47 | 0.17 |
| Байгууллагаас авах авлага | 51,875.70 | 39,298.52 | (12,577.20) | (11.43) |
| Хувь хүмүүсээс авах авлага | 265,035.05 | 134,660.57 | (130,374.48) | (118.50) |
| **Дүн** | **317,538.75** | **427,559.36** | **110,020.58** | **100.00** |

*Эх сурвалж: Хутаг-Өндөр сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 4,000.0 мянган төгрөгийн дараах авлага байна. Үүнд:

- ✓ Ерөнхий боловсролын сургууль нярваас авах авлага 3,000.0 мянган төгрөг,
- ✓ Засаг даргын тамгын газрын ажиллагсадтай холбоотой 1,000.0 авлагын үлдэгдэл байна.

Эдгээр нь жижиг дунд үйлдвэрлэл хөгжихгүй, ажлын байр нэмэгдэхгүй, сангийн хөрөнгө багасах, зээлийн эргэлт удаашрах үр дагавартай байна.

### 3.5.6 Бараа материал

Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 14.0 хувиар өссөн байна.

*Хүснэгт №3. Бараа материалын үлдэгдэл* *(мянган төгрөг)*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Тусгай зориулалтын материал | 18,692.19 | 18,143.87 | (548.32) | (0.66) |
| Эм боох материал | - | 115,845.58 | 115,845.58 | 139.77 |
| Бэлэн бүтээгдэхүүн | 7,258.48 | 907.71 | (6,350.78) | (7.66) |
| Бичиг хэргийн материал | 6,871.06 | 7,567.40 | 696.34 | 0.84 |
| Аж ахуйн материал | 111,391.49 | 109,543.88 | (1,847.61) | (2.23) |
| Сэлбэг хэрэгсэл | 4,311.40 | - | (4,311.40) | (5.20) |
| Түлш, шатах тослох материал | 11,721.11 | 12,927.46 | 1,206.35 | 1.46 |
| Барилгын засварын материал | 31,834.46 | 6,087.06 | (25,747.40) | (31.06) |
| Хүнсний материал | 26,013.74 | 12,172.41 | (13,841.32) | (16.70) |
| Бусад хангамжийн материал | 158,870.95 | 175,578.15 | 16,707.20 | 20.16 |
| Биологийн хөрөнгө | - | 1,075.36 | 1,075.36 | 1.30 |
| **Дүн** | **376,964.88** | **459,848.86** | **82,883.98** | **100.00** |

*Эх сурвалж: Хутаг-Өндөр сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Бараа материалын үлдэгдэлд тайлант оны эцэст худалдан авсан 135,530.83 мянган төгрөгийн тусгай зориулалтын материал, бичиг хэргийн материал, эм боох материал, түлш, шатах тослох материал, бусад хангамжийн материал, биологийн хөрөгийг тухайн төсвийн хэмнэлтийн горимд ажиллаж төсөв үлдсэн шалтгаанаар нөөцөлсөн.

### 3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 25.6 хувиар өссөн байна.

*Хүснэгт №4. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл* *(мянган төгрөг)*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Барилга, байгууламж, орон сууц | 11,283,234.86 | 16,045,994.55 | 4,762,759.68 | 39.10 |
| Хуримтлагдсан элэгдэл | (5,245,484.29) | (6,053,341.51) | (807,857.22) | (73.21) |
| Авто-тээврийн хэрэгсэл | 209,490.00 | 431,139.43 | 221,649.43 | 10.16 |
| Хуримтлагдсан элэгдэл | (120,975.56) | (151,064.88) | (30,089.33) | (7.75) |
| Машин тоног төхөөрөмж(компьютер) | 597,847.52 | 1,132,310.35 | 534,462.83 | 64.06 |
| Хуримтлагдсан элэгдэл | (220,162.33) | (474,788.63) | (254,626.30) | (18.42) |
| Тавилга, аж ахуйн эд хогшил | 300,285.30 | 350,770.63 | 50,485.33 | 17.40 |
| Хуримтлагдсан элэгдэл | (111,656.65) | (163,083.34) | (51,426.69) | (6.73) |
| Зам, гүүрийн байгууламж | 564,774.70 | 564,774.70 | - | 79.33 |
| Хуримтлагдсан элэгдэл | (43,444.21) | (86,888.41) | (43,444.21) | (13.82) |
| Бусад үндсэн хөрөнгө | 2,393,440.07 | 407,229.46 | (1,986,210.61) | 13.88 |
| Хуримтлагдсан элэгдэл | (218,147.20) | (177,856.07) | 40,291.13 | (6.90) |
| Дуусаагүй барилга, байгууламж | 2,390.00 | 2,390.00 | - | - |
| Ном | 87,647.52 | 93,433.40 | 5,785.88 | 0.03 |
| Програм хангамж | 3,665.00 | 9,500.00 | 5,835.00 | 3.61 |
| Хуримтлагдсан элэгдэл | (311.04) | (1,456.29) | (1,145.25) | (0.31) |
| Бусад биет бус хөрөнгө | 214,814.40 | 248,380.40 | 33,566.00 | - |
| **Дүн** | **9,697,408.09** | **12,177,443.77** | **2,480,035.69** | **100.00** |

*Эх сурвалж: Хутаг-Өндөр сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 365,808.9 мянга, балансаас балансад шилжүүлэн авсан 4,296,399.0 мянга, шилжүүлсэн авсан бүтцийн өөрчлөлтөөр 59,879.9 мянга, бусад 871,192.2 мянга, хандиваар авсан 357,100.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн, акталсан 51,216.2 мянга, шилжүүлсэн 2,223,432.7 мянга, шилжүүлсэн бүтцийн өөрчлөлтөөр 47,397.9 мянган төгрөгөөр хасагдсан байна.

### 3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн үлдэгдэл өмнөх оноос 2,072.0 хувиар өссөн байна.

*Хүснэгт №5. Нийт өр төлбөрийн үлдэгдэл* *(мянган төгрөг)*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өссөн+ Буурсан - | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| *Богино хугацаат өр төлбөр дүн* | *791.87* | *16,408.10* | *15,616.23* | 100.00 |
| Ажилчидтай холбогдсон өглөг | - | 1,274.94 | 1,274.94 | 8.16 |
| Бараа үйлчилгээний зардлын өглөг | - | 12,609.81 | 12,609.81 | 80.75 |
| Байгууллагад төлөх өглөг | 121.74 | 300.00 | 178.27 | 1.14 |
| Татварын өглөг /ТӨҮГ/ | 670.13 | 634.79 | (35.35) | (0.23) |
| Дансны өглөг /ТӨҮГ/ | - | 1,588.56 | 1,588.56 | 10.17 |
| **Нийт дүн** | **791.87** | **16,408.10** | **15,616.23** | **100.00** |

*Эх сурвалж: Хутаг-Өндөр сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд Эрүүл мэндийн төв 12,909.8 мянга, Илчит хутаг ОНӨААТҮГ 2,222.4 мянга, Ерөнхий боловсролын сургуулийн 561.0 мянга, Соёлын төв 713.9 мянган төгрөгийн өглөг байна.

### 3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 27.6 хувиар өссөн байна.

*Хүснэгт №6. Засгийн газрын хувь оролцоо* *(мянган төгрөг)*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт/+/, бууралт /-/ | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 6,576,839.02 | 6,576,839.02 | - | - |
| Өмч /төрийн/ /ТӨҮГ/ | - | 743,295.18 | 743,295.18 | 25.18 |
| Хуримтлагдсан үр дүн | 1,011,880.72 | 2,756,639.69 | 1,744,758.97 | 59.11 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 3,079,126.36 | 3,542,559.17 | 463,432.82 | 15.70 |
| **Дүн** | **10,667,846.09** | **13,619,333.06** | **2,951,486.97** | **100.00** |

*Эх сурвалж: Хутаг-Өндөр сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 2,951,486.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны үр дүн, үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт данс буурснаас шалтгаалжээ.

### 3.5.10 Орлогын данс

Хутаг-Өндөр сумын ИТХ-ын “2021 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 2021 оны 04/05 дугаар хуралдааны тогтоолоор батлагдсан урсгал орлогыг 6.4 хувиар давуулан биелүүлсэн байна.

*Хүснэгт № 7. Сумын төсвийн орлого* *(мянган төгрөг)*

| № | Үзүүлэлт | төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хэтрэлт +, хэмнэлт- | хувь |
|---|---|---|---|---|---|
| **1** | **Урсгал орлого** | **406,622.75** | **513,037.24** | **106,414.49** | 126.17 |
| **2** | Татварын орлого | 324,794.35 | 379,506.59 | 54,712.24 | 116.85 |
| **2.1** | Орлогын албан татвар | 82,500.00 | 103,931.00 | 21,431.00 | 125.98 |
| | Үйл ажиллагааны орлого | 43,500.00 | 48,114.00 | 4,614.00 | 110.61 |
| | Хөрөнгийн орлого | 29,000.00 | 42,027.00 | 13,027.00 | 144.92 |
| | Шууд бус орлого | 10,000.00 | 13,790.00 | 3,790.00 | 137.90 |
| **2.2** | Хөрөнгийн албан татвар | 5,280.00 | 7,368.00 | 2,088.00 | 139.55 |
| | Бууны албан татвар | 5,280.00 | 7,368.00 | 2,088.00 | 139.55 |
| | Малд ногдуулах албан татвар | - | 151,430.00 | 151,430.00 | - |
| **2.3** | Бусад татвар, төлбөр, хураамж | 34,911.60 | 33,192.10 | (1,719.50) | 95.07 |
| | Улсын тэмдэгтийн хураамж | 7,000.00 | 9,724.00 | 2,724.00 | 138.91 |
| | Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр | 7,000.00 | 1,562.00 | (5,438.00) | 22.31 |
| | Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 6,600.00 | 7,635.60 | 1,035.60 | 115.69 |
| | Газрын төлбөр | 14,311.60 | 14,270.50 | (41.10) | 99.71 |
| | Байгалийн нөөц ашигласны төлбөр | 202,102.75 | 235,015.49 | 32,912.74 | 116.29 |
| | Ойн нөөц ашигласны төлбөр | 118,140.00 | 150,649.00 | 32,509.00 | 127.52 |
| | Ан амьтны нөөц ашигласны төлбөр | 1,000.00 | 1,070.00 | 70.00 | 107.00 |
| | Ус, рашааны нөөц ашигласны төлбөр | 2,500.00 | 2,833.74 | 333.74 | 113.35 |
| | Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр | 80,462.75 | 80,462.75 | - | 100.00 |
| **3** | Татварын бус орлого | 81,828.40 | 133,530.65 | 51,702.25 | 163.18 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **3.1** | Торгуулийн орлого | 56,378.90 | 99,464.29 | 43,085.39 | 176.42 |
| **3.2** | ТБӨОрлого | 25,449.50 | 34,066.36 | 8,616.86 | 133.86 |

*Эх сурвалж: Хутаг-Өндөр сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Зарим нэр төрлийн орлогын төлөвлөгөө биелэхэд дараах хүчин зүйлс нөлөөлсөн байна. Үүнд:

- Бууны албан татвар, Улсын тэмдэгтийн хураамж өмнөх оны дутуу төлөлтүүд болон галт зэвсэгийн бүртгэл тооллого хийгдсэн, Иргэдийн авах үйлилгээ нэмэгдсэн,
- Ойн нөөц ашигласны төлбөр Байгаль орчны газраас ирүүлж байгаа модны хуваарь өөрчлөгдсөн, талбай тусгаарлалтын үнэ өөрчлөгдсөн,
- 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралдааны 3/03 тоот тогтоолоор малын тоо, толгойн албан татварын хувь хэмжээг 2021 оны төсөв батлагдсанаас хойш Хууль зүйн яамаар хянуулан хуулийн нэгдсэн мэдээллийн санд бүртгүүлсэнээс үүдэж орлогын төлөвлөгөөг батлаагүйтэй тус тус холбоотой байна.

Харин зарим нэр төрлийн орлогын төлөвлөгөө тасарсан нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласаны төлбөр нь 22 хувийн гүйцэтгэлтэй буюу 5438,0 мянган төгрөгөөр тасарсан нь улс орон даяар хөл хорио тогтоон бүтээн байгуулалтын ажил хийгдээгүй, улирал нь өнгөрсөнтэй холбоотой байна.

### 3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Хутаг-Өндөр сумын ИТХ-ын хуралдааны тогтоолд төсөвт байгууллагын өөрийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас, гүйцэтгэлээр 294.0 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

*Хүснэгт 8. Төвлөрүүлэх орлого* *(мянган төгрөг)*

| Орлогын төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| Засаг даргын тамгын газар | 635.0 | 600.0 | (35.0) | 2.7 |
| Соёлын төв | 1,768.4 | 500.0 | (1,268.4) | 97.3 |
| **ДҮН** | **2,403.4** | **1,300.0** | **(1,303.4)** | **100.0** |

*Эх сурвалж: Хутаг-Өндөр сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

## Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 4,743,732.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 4,743,732.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 4,743,732.1 мянган төгрөгөөр өөрчлөлт оруулаагүй баталсан байна.

## Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан 4,743,732.1 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 4,087,861.8 мянган төгрөгийг урсгал зардалд, 230,306.5 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 156,157.3 мянган төгрөгийг эргэн төлөгдөх зээлд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 2,855,683.0 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 1,309,213.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 99,606.7 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 66,374.0 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 190,881.2 мянган

төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 223,363.6 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 2,855,683.0 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 1,444,163.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 99,606.7 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 28,432.4 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас нийт 4,654,520.4 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, эрүүл мэндийн даатгалын 37,941.6 мянган төгрөгийг дутуу олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,405,954.3 мянган төгрөг буюу 92.9 хувьтай байгаа дараах хүчин зүйлсээс шалтгаалсан байна. Үүнд:

- Урсгал зардлын гүйцэтгэлийн материаллаг дүнтэй зардлуудын дутуу зарцуулсан нь Ковид-19 цар тахал, малын гоц халдварт өвчин гарсантай холбоотой хөл хорио тогтоож томилолтын болон бараа үйлчилгээний бусад зардал хэмнэгдсэн байна.
- Урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан 24,738.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт, 54,556.9 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

**Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар 3,449.2 мянга, Засаг даргын нөөц хөрөнгөөс 39,691.2 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 574.945.3 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 68,010.8 мянга, нийт 686,096.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин болон нэмэгдэл урамшуулалд 104,638.8 мянга, хангамж болон бараа материалын зардалд 8,815.4 мянга, нормативт зардал 189,696.5 мянга, эд хогшил, урсгал засварын зардалд 66,274.1 мянга, томилолт зочны зардалд 960.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 12,300.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 177,919.8 мянга, АО-оос олгох  бусад тэтгэмж, урамшуулалд 100,450.0 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 43.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

**3.7 Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 153 мэдээллээс 141 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийн хугацаа болоогүй, 12 мэдээллийг хугацаа хоцроож, байршуулсан байна. Тухайлбал:

- ✓ Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбар, улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл 6 сар, 2-р улирал, засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл 6 сарын мэдээлэл,
- ✓ Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэлийг 6 сарын мэдээлэл,
- ✓ Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төрийн хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийн 11 сарын мэдээлэл, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний бүтэн жилийн мэдээлэл.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1.1 "тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор", 6.4.4 "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг"д заасантай тус тус нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн зөрчлийг арилгах 3 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

*Хүснэгт 3* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт (мянган төгрөг)

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Биелэгдээгүй | | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | |
| Зөвлөмж | 3 | - | 3 | - | - | - | 100.0 |
| Нийт | 3 | - | 3 | - | - | - | 100.0 |

### 3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 7 төсвийн байгууллага, 1 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 4 тусгайн сангийн нийт 12 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 7 байгууллагад дүгнэлт гаргаж, 4 байгууллага түүврээр хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 6, “Хязгаарлалттай” 1 /Илчит хутаг ОНӨААТҮГ/ дүгнэлт өгсөн байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 5,890,281.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 4,866,913.8 мянган төгрөгийн 26 алдааг аудитын явцад залруулж, 36,424.3 мянган төгрөгийн 9 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 827,349.3 мянган төгрөгийн 22 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 261,031.1 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 22 зөвлөмжийг хүргүүллээ.

### 3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Үндсэн хөрөнгө эзэмшилдээ байгаа элэгдэл хорогдлын шимтгэлээрээ анхны үнийг нөхсөн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох шаардлагатай байна. Үлдэх өртөг тэг үлдэгдэлтэй ашиглалтын хугацаа бүрэн дууссан хөрөнгөнд нэмж элэгдлийн зардал байгуулагдахгүйгээс тухай тайлант хугацааны элэгдлийн зардал үнэн зөв илэрхийлэгдэхгүй дутуу тайлагнагдаж байна.

Нэмэлт санхүүжилтийн данс болон үндсэн үйл ажиллагааны зориулалтаас бусад арга хэмжээний зардлыг зарцуулахдаа зардлын эдийн засгийн ангиллаар зарцуулахаар зарцуулалтын эрх олгоогүйгээс шалтгаалж, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тайлангийн зардал, бараа материал, үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн дүнтэй зөрүүтэй илэрхийлэгдэж байнгааг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

### 3.11 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад тусгай сангийн дансны бичилтийг НБББВ-ыг мөрдөөгүй, авлагыг хугацаагаар нь богино болон урт хугацаат авлагаар ангилж, санхүүгийн тайланг үнэн зөв илэрхийлээгүйгээс бодитой мэдээллээр хэрэглэгчдийг хангаж чадахгүй эрсдэл үүсч байна.

### 3.12 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийсэн бөгөөд нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгаж тусгасан.

### 3.13 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Аудитаар нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж баталгаажуулав. Үүнд:

- Мэдээллийн технологийн аюулгүй байдал, санхүүгийн программд нэвтрэх эрхийн хязгаарлалтын талаар албан ёсны шийдвэр гаргаж баталгаажуулаагүй нь мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй,
- Дотоод хяналтын журам боловсруулж мөрдөөгүй, санхүүгийн үйл ажиллагаа, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад тавих дотоод хяналт хангалтгүй нь дотоод хяналтын талаарх Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 498,532.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 175,711.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 320,822.1 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмж өгсөн.

### 4.1 Залруулсан алдаа

4.1.1 Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд орон нутгийн хөгжлийн санд 175,711.9 мянган төгрөгийг Төсвийн гүйцэтгэлийн тайланд санхүүжүүлэх эх үүсвэр, зардлын гүйцэтгэлийг тайлагнаагүй, мөнгөн хөрөнгийн эхний, эцсийн үлдэгдэлийг тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

### 4.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

### 4.3 Албан шаардлага

4.3.1 Сум дундын ойн анги нормын хувцас зөөлөн эдлэлийн зардлаас ажилчдад подволк худалдан авсан байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4 дэхь заалтыг хэрэгжүүлээ, 5 сая төгрөгөөр дээш үнийн дүнтэй орлого, зарлагын 92,724.5 мянган төгрөгийн гүйлгээг мэдээлээгүйд зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүллээ.

4.3.2 Сум хөгжүүлэх сангийн гүйлгээг бүртгэхдээ цаг хугацааны дараалаар зээлдэгчийн хүү, алданги, авлагыг тухай бүр нь бүртгэхгүй нийт дүнгээр нь дансны бичилт хийж бүртгэсэн байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4, 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалыг хэрэгжүүлээгүйд зөрчлийг арилгаж, таслан зогсоох албан шаарлага хүргүүллээ.

4.3.3 Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэх төсөл арга хэмжээг сумын ИТХ-аар баталсан боловч, төсөл арга хэмжээн дотор хөтөлбөр гэсэн нэршилээр задаргаагүй батлуулж сумын Засаг даргын захирамжаар зарцуулсан, Орон нутгийн хөгжлийн сангийн гүйлгээг бүртгэхдээ цаг хугацааны дараалал болон арга хэмжээг санхүүжүүлсэн ажил гүйлгээ бүрээр журналд бүртгэхгүй бөөн дүнгээр нь дансны бичилт хийж бүртгэсэнд зөрчлийг арилгаж, таслан зогсоох албан шаардлага хүргүүллээ.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Шилэн данстай холбоотой асуудал***

*1.1. Илрүүлэлт:*

Шилэн дансны нэгдсэн системд 153 мэдээлэл байршуулахаас 12 мэдээллийг хугацаа хоцруулан байршуулсан байна.

*1.2. Өгсөн зөвлөмж:*

ТТЗ-ийн шилэн дансны мэдээлэл байршуулахдаа мэдээлэл үнэн зөв, бодитой, ойлгомжтой, иж бүрэн, ач холбогдолтой, тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх зарчмуудыг баримталж эрх бүхий байгууллагаас хуулийн хэрэгжилтийг хангах талаар арга зүйн зөвлөгөө авч ажиллах.

***2. Санхүүгийн тайлагналтай холбоотой асуудал***

*2.1. Илрүүлэлт:*

2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсгийг хангаж ирүүлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 "Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна"-д заасантай нийцэхгүй байна.

*2.2. Өгсөн зөвлөмж:*

Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн иж бүрдлийг хуульд заасны дагуу гаргаж ирүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 10-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| ***1*** | ***2*** | ***3*** | ***4*** | ***5*** | ***6*** | ***7*** | ***8*** | ***9*** | ***10*** | ***11*** | ***12*** |
| 1 | **Хутаг-Өндөр сумын Засаг дарга** | **6** | **498.532.0** | **1** | **175,711.9** | **-** | **-** | **3** | **322,820.1** | **2** | **0** |